

Батлав.



Эрчим хүчний сургуулийн захирал Б.Бат-Эрдэнэ

## “ЭРЧИМ ХҮЧНИЙ ДАМЖУУЛАЛТ ТҮГЭЭЛТИЙН ИННОВАЦИ”

сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж

2024 оны 09-р сарын 17

Улаанбаатар хот

### Нэг. Зорилго

Онол практикийн ач холбогдол бүхий судалгааны шинэ бүтээл, үзэл санааг хөгжүүлэх, олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, харилцан хамтын ажиллагааг дэмжихэд чиглэгдэнэ.

### Хоёр. Хурлын хамрах хүрээ

Эрчим хүчний салбарын ИТА болон их дээд сургуулиудын эрдэмтэн, багш, судлаач оюутнууд хамрагдана.

### Гурав. Зохион байгуулагдах хугацаа, байршил

2024 оны 10-р сарын 15-ны өдрийн 09:00 – 17:00 цагт ШУТИС-ийн 8-р байрны 12 давхарын хурлын өрөөнд болно.

### Дөрөв. Өгүүлэлд тавигдах шаардлага

Эрдэм шинжилгээний хуралд ирүүлэх илтгэл, өгүүлэлд эрдэм шинжилгээний судалгаа, практик туршилтын үр дүнг тусгасан байна. Өгүүлэл нь дараах дэс дараалалтай байна. Үүнд:

1. Хураангуй
  2. Оршил (Судалгааны ажлын ач холбогдол тухайн сэдэв ямар түвшинд онцлог чухал болохыг дурдах мөн судлагдсан байдал, зорилго, өгүүллийн бүтцийг багтаасан байна)
  3. Судалгааны ажлын объектын тухай (судалгааны ажил гүйцэтгэсэн туршилтын объект, системийн тухай мэдээлэл)
  4. Судалгааны ажлын арга зүй (зохиогчийн дэвшүүлж буй шинэлэг санааг тусгасан байна)
  5. Судалгааны ажлын үр дүн (туршилт судалгааны үр дүнг тоон болон чанарын харьцуулалт хийж зураг, схем, хүснэгтээр нотлон тайлбарлан бичих)
  6. Дүгнэлт (судалгааны ажлын ерөнхий дүгнэлт)
  7. Эшлэл (ашигласан эрдэм шинжилгээний өгүүлэл)
- Судалгааны өгүүлэлдээ гадаад, дотоодын эх сурвалж, эшлэл 5-оос доошгүйг ашиглаж оюуны өмчийн эрхийг хүндэтгэсэн байх
  - Судалгааны өгүүллийг 6 хуудас (нүүр)-нд багтаан Англи эсвэл Монгол хэл дээр бичнэ.
  - Өгүүллийг ШУТИС-ийн эрдэм шинжилгээний өгүүлэл бичих жишиг загвараар хүлээж авна (<https://research.must.edu.mn/page/104>).



## Тав. Өгүүллийг хүлээн авах ба шалгаруулах

### 5.1 Өгүүллийг хүлээн авах

Өгүүллийг 2024.10.10-ны өдрийн 17:00 цаг хүртэл [baigali@must.edu.mn](mailto:baigali@must.edu.mn) цахим хаягаар PDF болон DOC өргөтгөлтэйгөөр хүлээн авна. Имэйл-ын subject болон өгүүллийн файлын нэр адил байх бөгөөд дараах загварын дагуу явуулна.

Файлын нэр: Нэгдүгээр зохиогчийн нэр\_Өгүүллийн нэр

Жишээ нь: Baigali\_Erchim khuchnii unuugiin baidal

### 5.2 Шалгаруулалт

Эрдэм шинжилгээний бага хурлыг 2 үе шаттайгаар зохион байгаална. Ирүүлсэн өгүүллүүдийг шүүгчдийн бүрэлдэхүүн дүгнэн, эхний 6 өгүүллийг шалгаруулна. Эдгээр өгүүллүүдийг эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлэх бөгөөд хурал болох өдрөөс 2 өдрийн өмнө зохиогч нарт мэдэгдэнэ.

Хуралд хэлэлцүүлэгдэх илтгэлийн танилцуулга 15 минутаас хэтрэхгүй. Асуулт хариулт 5 минут байна.

Эрдэм шинжилгээний хуралд ирүүлсэн бүх өгүүллүүд нь эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд хэвлэгдэнэ.

### Зургаа. Шагнал, урамшуулал

I байр. Нэг бүтээл – Өргөмжлөл, мөнгөн шагнал

II байр. Нэг бүтээл – Өргөмжлөл, мөнгөн шагнал

III байр. Нэг бүтээл – Өргөмжлөл, мөнгөн шагнал

### Долоо. Шүүгчдийн бүрэлдэхүүн

**Дарга:** ЭХС-ийн ЦИС-ын профессор, доктор (Ph.D.) Б.Сэргэлэн

**Гишүүд:**

ЭХС-ийн захирал, профессор, доктор (Ph.D.) Б.Бат-Эрдэнэ

ЭХС-ийн ЦИС-ын дэд профессор, доктор (Ph.D.) Б.Бат-Ундрал


ЭХС-ийн ЦИС-ын ахлах багш, доктор (Ph.D.) С.Мөнхжаргал

### Найм. Зохион байгуулах комисс

“Инженер, технологийн дээд боловсрол” (MJEED) төслийн “Эрчим хүчний дамжуулалт түгээлтийн инновацийн судалгаа” судалгааны баг.

Хянасан:


ЭХС-ийн ЭНБД, доктор (Ph.D)



Д.Үлэмж


Боловсруулсан:

ЭХС-ийн ЦТС-ын багш, доктор (Ph.D)



Б.Түвшинбаяр

ЭХС-ийн ЦИС-ын багш, доктор (Ph.D)



Э.Байгаль